


ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 01 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН


2019.01.23

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2019 оны газрын төлбөрийн орлого 163 811.8 сая төгрөгөөр батлагдсан. Үүнээс: 2019 оны 1 сарын байдлаар 3'878'646 сая төгрөг буюу 2,3%-ийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээд байна.



Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар 3 байршилд дуудлага худалдааг зохион байгуулахаар зар мэдээг газрын цахим бирж болох www.mle.mn болон байгууллагын www.govisumber.gazar.gov.mn сайт, өдөр тутмын сонин “Өдрийн сонин”-д байршуулаад байна.



2019 оны 01 дүгээр сарын 18-нд гахайн африкийн мялзан өвчин Сүмбэр суманд гарсантай холбогдуулан сумын Засаг дарга Д.Амарсайхан, Онцгой байдлын газрын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ш.Билэгдэмбэрэл, Цагдаагийн хэлтсийн НХЖХТ-ийн дарга Д.Түмэнжаргал нартай хамт хорио цээрийн дэглэм тогтоох хяналтын газрын байршил болон

устгалын цэгийн байршлыг тогтоон зурагт оруулан, АЗ хэмжээтэйгээр хэвлэн сумын Онцгой комисст өгсөн.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1. Барилгын хяналтын чиглэлээр:


- Шивээговь сум 21-р зөрлөг “Страто”ХХК-ий нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэлтэй танилцсан. Ажлын явц нүүрс баяжуулах үйлдвэрийн барилга угсралтын явц 75%-тай, нүүрсний агуулах 60%-тай ажил гүйцэтгэж байна.



Сургалт, судалгааны чиглэлээр:

Байгууллагын хэмжээнд 2019 онд иргэд, олон нийтрүү чиглэсэн сургалт сурталчилгааны төлөвлөгөө, зохион байгуулах аян зэргүүдийн төлөвлөгөөг графикчилсан байдлаар гаргаж сургалт, судалгааны ажлуудыг зохион байгуулж эхлээд байна. Үүнээс:

“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ” сэдэвт сургалтыг 2019 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежтой хамтран барилгын материал үйлдвэрлэгч, барилгын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын ХАБЭА хариуцсан ажилтнуудад зориулсан анхан шатны сертификат олгох 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд төрийн өмчит болон хувийн хэвшлийн 7 байгууллагын 14 ажилтан хамрагдсан бөгөөд, тодорхой дадлага сургууль хийх боломжтой орчин нөхцөлд, мэргэжлийн багшаар заалган, орон нутагтаа зардал мөнгө хэмнэн мэдлэг, мэргэшлээ дээшлүүлсэн ач холбогдол сайтай сургалт боллоо.



ТАЙЛАН ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

Б.ОТГОНЧИМЭГ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

О.БОЛОР-ЭРДЭНЭ

/Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав/